



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 4/61

Мандалговь

Хүүхдийн хөгжил, оролцооны сургалт
зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумдын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд "Хүүхдийн хөгжил оролцоо" сэдэвт сургалтыг 2021 оны 07 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 1.900,000 (Нэг сая есөн зуун мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг сургалтад идэвхитэй хамруулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтэн (Р.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

5. Сургалтыг чанартай зохион байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж, тайлан, үр дүнг 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Ахлах мэргэжилтэн (Р.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

291190121